



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/16.

Эг

**Агуулахын эд хөрөнгө, бараа
материалын тооллого зохион байгуулах тухай**


Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх заалт, 72 дугаар зүйлийн 72.4, 72.5 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хагас жилийн тайлантай холбогдуулан агуулахын эд хөрөнгө, бараа материалын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч: Б.Энхчимэг (Арга зүйч)
Нарийн бичгийн дарга: Б.Соёлмаа (Үйлчлэгч)
Гишүүн: Б.Мөнхнаран (Жижүүр, манаач)

2. Тооллогыг 2024 оны 05 дугаар сарын 23-ноос 2024 оны 05 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулж мэдээ тайланг 2024 оны 06 дугаар сарын 02-ний өдөр танилцуулан тайлагнахыг ажлын хэсгийн нарийн бичиг /Б.Соёлмаа/-д даалгасугай.

ЭРХЛЭГЧ



А.ХАНДЦОО